



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ


2021 он 10 сарын 30 өдөр

№ 01

Улаанбаатар хот

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн 7.20 дугаар заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- 1.1 “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны үйл ажиллагааны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшиүүлэх хорооны үйл ажиллагааны журам”-ыг гуравдугаар хавсралтаар, “Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
- 1.2 Эдгээр журмыг үйл ажиллагаанда мөрдлөг болгон ажиллахыг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагын багт үүрэг болгосугай.
- 1.3 Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Ж.Жаргалсайхан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
.....
/Ж.ЖАРГАЛСАЙХАН/





“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 он 10 сарын 30 өдөр

№ 02

Улаанбаатар хот

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн 7.20 дугаар заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- 1.1 “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- 1.2 “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын журмыг мөрдлөг болгон ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.
- 1.3 Эдгээр журмын дагуу ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал настай холбогдох гэрээг байгуулж үр дүнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга / Ж. Жаргалсайхан /-д даалгасугай



- 1.5. Үйл ажиллагааг харилцан ашигтэй үр дүнтэй түргэн шуурхай ажил хэрэгчээр зохион байгуулж холбогдох зардалын төсвийг тодорхойлон ТУЗ-ийн хурлаар оруулж хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Орхон, Л.Ариунаа, Ч.Нэргүй) нарт даалгасугай



A large, dark blue handwritten signature, which appears to be "Ж.ЖАРГАЛСАЙХАН", is located at the bottom right of the document. It is written in a cursive style with some vertical strokes.



“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 он 10 сарын 30 өдөр

№ 04

Улаанбаатар хот

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн 7.31.1 болон 7.31.2 дугаар заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- 1.1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2021-оны дөрөвдүгээр улирлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, 2022-оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- 1.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж шаардагдах төсөв хөрөнгийн хэмжээг тогтоож ТУЗ-ийн хуралд оруулан батлуулахыг Гүйцэтгэх захирал / Н. Алтансүх /-д даалгасугай.
- 1.3. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд шаардлагатай бодлого үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.
- 1.4. Хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Ж. Жаргалсайхан/-д даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
...../Ж.ЖАРГАЛСАЙХАН/